



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: (976-11) 32-35-89,
E-mail: info@mecss.gov.mn, http://www.mecss.gov.mn

2017. 11. 09

№

4/10682

танай _____-ны № _____-т

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА НАРТ**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/244 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн нэршил, хаягийн бичвэрийн тухай зөвлөмж” боловсруулан хүргүүлж байна.

Энэхүү зөвлөмжийг баримтлан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын дээрх тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.


Хавсралт: 6 хуудастай

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА _____ Д.ЭРДЭНЭЧИМЭГ



09 11255

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын яамны Ерөнхий боловсролын
бодлогын газрын даргын 2017 оны
11. дүгээр сарын 09-ны өдрийн
4/10612 дугаар албан бичгийн хавсралт



ЗӨВЛӨМЖ

*Ерөнхий боловсролын сургуулийн
нэршил, хаягийн бичвэрийн тухай*

Нэг. Нийтлэг үндэслэл

Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн оноосон нэр, хичээлийн байрны гадна байршуулсан хаягийн өнөөгийн байдлыг аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газраас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тус яамнаас 2016-2017 оны хичээлийн жилд судалж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулсан.

Ерөнхий боловсролын сургуулийн оноосон нэр болон хичээлийн байрны гадна байрлах хаягийн самбарын бичвэрийг цэгцлэх зорилгоор хийсэн судалгаагаар:

- i. улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн нэр 90 гаруй янзаар бичигдсэн байна. Сургуулийн нэр ихэндээ оноосон нэр, сум, багийн нэр болон дэс дугаар эсхүл оноосон нэр-дугаар хосолсон хэлбэрээр бичигдсэн байна.
- ii. ерөнхий боловсролын сургуулиуд Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль тогтоомжид тусгайлан заагаагүй нэр томъёо ашиглах явдал нилээд байна. Тухайлбал, ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль, суурь боловсролын сургууль, дунд сургууль, тусгай дунд сургууль, 9 жилийн эсхүл 12 жилийн сургалттай сургууль, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа лаборатори сургууль, үндэсний лаборатори сургууль, гүнзгийрүүлсэн сургалттай лицей сургууль гэх мэт.
- iii. ерөнхий боловсролын сургуулийн нэрийн өмнө сургуулийн хэв шинж (*төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, тусгай, олон улсын хөтөлбөрийн сургалттай*)-ийг хэрэглэх явдал түгээмэл байгаа нь сурагчдын дунд ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлыг үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.
- iv. ерөнхий боловсролын зарим сургуулийн улсын бүртгэлийн гэрчилгээнд 2000 оноос хойш нэмэлт, өөрчлөлт ороогүй нь сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд бичигдсэн сургалтын байгууллагын нэртэй нийцэхгүй байх тохиолдол их байна.
- v. хичээлийн байрны гадна байршуулсан хаягийн бичвэр улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хуулийн этгээдийн албан ёсны нэрээс зөрүүтэй бичигдэж байна.
- vi. гавьяат үйлстний нэрэмжит, төрийн дээд одон болон аймаг, нийслэл, сум, дүүргийн тэргүүний сургууль эсхүл ...түшиц сургууль зэрэг бичвэрийг хаягийн бичвэрт их бичиж байна. Иймээс хаягийн бичвэр хэт урт болох төдийгүй найруулга зүйн алдаатай байх тохиолдол нэлээд байна.

- vii. боловсролын сургалтын байгууллагын нэршилд тавих нэгдсэн/тусгайлсан шаардлага байхгүйгээс сургууль бүр сургуулийн нэрийг хаягийн бичвэрт сонирхлоор бичиж байна.

Хоёр. Ерөнхий боловсролын сургуулийн нэр, хаягийн бичвэр

Сургуулийн оноосон нэрийн өгөгдөл, бичиглэлийг судалсан судалгаанд үндэслэн улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн нэрийг хууль тогтоомжид нийцүүлэн цэгцлэх ажлыг зохион байгуулахтай холбогдуулан дараах “ЗӨВЛӨМЖ”-ийг өгч байна.

Аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газар нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/244 дүгээр тушаалаар баталсан дор дурдсан нэршлийн загварт нийцүүлэн ерөнхий боловсролын сургуулийн нэрийг эрх бүхий этгээд /аймаг, нийслэлийн Засаг дарга/-ийн шийдвэрээр баталгаажуулна:

1. Ерөнхий боловсролын сургууль;
2. Ерөнхий боловсролын лаборатори сургууль;
3. Ерөнхий боловсролын цогцолбор сургууль;
4. Их, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль.

Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулсан “Ерөнхий боловсролын сургуулийн нэршил”-ийг мөрдөхтэй холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг Боловсрол, соёл, урлагийн газар/Боловсролын газар хариуцаж, улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах асуудлыг орон нутаг дахь улсын бүртгэлийн байгууллагатай хамтран зохион байгуулна. Харин сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ шинэчлэх асуудлыг Боловсрол, соёл, урлагийн газар/Боловсролын газар хариуцна. Хэрэв сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн асуудлыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс хариуцдаг тохиолдолд тэдэнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, энэхүү зөвлөмжийг баримтлан ерөнхий боловсролын сургуулийн нэрийг цэгцлэх ажлыг хамтран гүйцэтгэнэ.

Засаг даргын захирамжаар баталсан ерөнхий боловсролын сургуулийн нэршлийг улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, дардас болон хаягийн бичвэр, суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, үнэмлэхэд тус тус мөрдөнө.

1.Боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “...бага, дунд боловсролын сургалтын байгууллага нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор байна”, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг “Улсын бүртгэлийн байгууллага боловсролын сургалтын байгууллагыг сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд үндэслэн төрийн өмчийн, ашгийн төлөө бус, ашгийн төлөө гэсэн ангиллаар, энэ хуулийн 14, 14¹, 15 дугаар зүйлд заасан хэв шинжээр нь нэрлэж бүртгэнэ” гэж заасан байна.

Иймээс Боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг өмчийн хэлбэрээс үл хамаарч “ерөнхий боловсролын сургууль” гэсэн нэр томъёог сургалтын байгууллагын нэршилд хэрэглэнэ. Сургалтын байгууллагын нэршилд товчилсон нэр томъёо, үг хэллэг болон ром тоо тус тус хэрэглэхгүй.

Жишээлбэл, “Ерөнхий боловсролын сургууль” гэснийг “ЕБС, ЕБ сургууль” гэж, “15 дугаар сургууль” гэснийг “XV сургууль” гэж хэрэглэхгүй.

2. Сургуулийн хэв шинж, боловсрол эзэмшүүлэх хугацаа, төрийн дээд одон, гавьяат үйлстний нэрэмжит, улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн тэргүүний болон түшиц сургууль гэсэн бичвэрийг сургалтын байгууллагын нэр, хаягийн бичвэрт хэрэглэхгүй. Жишээлбэл:

Хуульд нийцсэн бичвэр	Хориглох бичвэр
Булган аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын сургууль	Булган аймгийн Сайхан сумын ЕБС Булган аймгийн Сайхан сумын төрөлжсөн сургалттай сургууль Булган аймгийн Сайхан сумын 12 жилийн ахлах сургууль Булган аймгийн Сайхан сумын 12 жилийн сургалттай дунд сургууль Монгол Улсын баатар Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит Сайхан сумын сургууль Сайхан сумын аймгийн тэргүүний сургууль Боловсролын их сургуулийн түшиц Сайхан сумын ерөнхий боловсролын сургууль

Сургалтын байгууллагын нэр, хаягийн бичвэрт сургуулийн хэв шинжийг бичиж байгаа нь сургууль, суралцагч хооронд ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлыг үүсгэж байна. Иймээс сургуулийн хэв шинж (*ердийн, гүнзгийрүүлсэн, төрөлжсөн, тусгай, олон улсын хөтөлбөрийн сургалттай сургууль*)-ийг сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хавсралт болох “Сургалт эрхлэх нөхцөл шаардлага”-ын “Сургуулийн хэв шинж” гэсэн хэсэгт тэмдэглэнэ.

3.Тухайн суманд нэгээс дээш сургууль үйл ажиллагаа эрхэлж байгаа тохиолдолд сумын нэрийг бичнэ.

Хуульд нийцсэн бичвэр	Хориглох бичвэр
Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБ-ын 3-р ахлах сургууль Дорноговь аймгийн Сайншанд сумын математик, гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 3-р дунд сургууль Дорноговь аймгийн Сайншанд сумын 12 жилийн 3-р бүрэн дунд сургууль

Харин тухайн аймаг, нийслэлд “цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор” бие даасан байгууллагаар бүртгэгдсэн бол Боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасныг баримтлан нэршлийг дараах байдлаар бичнэ. Хэрэв “цэцэрлэг, бага сургууль” нэг барилгад үйл ажиллагаа явуулдаг боловч тус тусдаа хуулийн этгээдээр бүртгэгдсэн тохиолдолд дор үзүүлсэн бичвэр хамаарахгүй.

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор

4. Ерөнхий боловсролын сургуулийг шагнасан төрийн дээд одон болон гавьяат үйлстний нэрэмжит болгосон шийдвэрийг тусгайлсан самбарт бичиж хичээлийн байрны дотор эсхүл гадна байршуулна. Жишээ нь: “Тус сургуулийг БНМАУ-ын Ардын их хурлын 1966 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 170 дугаар зарлигаар баатар хот Москвагийн нэрэмжит болгов”, “Тус сургуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 167 дугаар зарлигаар Алдан гадас одонгоор шагнав”.

5.Зарим аймагт орон нутгийн болон хувийн өмчийн сургуулиудыг өмчийн хэлбэр үл харгалзан эрх бүхий байгууллагаас нэгдсэн дугаар олгож байгаа тохиолдолд сум, баг, тосгоны нэрийг бичихгүй. Мөн Нийслэлийн Засаг даргын захирамжаар орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэрийг нэгдсэн байдлаар дугаараар олгож буй тохиолдолд “Нэгдсэн хаягжуулалт. Хаягийн бичвэрт тавих шаардлага MNS 6275:2016 Монгол Улсын стандарт”-ын “5. Хаягийн бичвэрт тавих ерөнхий шаардлагад хаягийн бичвэрт .. дүүрэг, ... зэрэг тодотгосон элементүүдийг заавал ашиглах шаардлагагүй” гэж заасны дагуу сургуулийн нэр, хаягийн бичвэрт байршил буюу “дүүрэг” бичих шаардлагагүй. Жишээлбэл:

Хуульд нийцсэн бичвэр	Хориглох бичвэр
Дархан-уул аймгийн ерөнхий боловсролын 11 дүгээр сургууль	Дархан-уул аймгийн ЕБ-ын 11-р сургууль Дархан-уул аймгийн ЕБ-ын XI сургууль Дархан-уул аймгийн Орхон сумын Салхит багийн 11-р сургууль /Энэ тохиолдолд Салхит багт 11 сургууль байгаа мэт ойлгогдож байна/
Нийслэлийн ерөнхий боловсролын 75 дугаар сургууль	Нийслэлийн Хан-Уул дүүргийн гүнзгийрүүлсэн сургалттай 75-р бүрэн дунд сургууль /Энэ тохиолдолд Хан-Уул дүүрэгт 75 сургууль ажилладаг мэт ойлгогдож байна. Бодит байдалд тус дүүрэг орон нутгийн өмчийн 18 сургуультай/
Нийслэлийн ерөнхий боловсролын 130 дугаар сургууль	Нийслэлийн Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 130-р бага сургууль / тус дүүрэгт бага сургууль 130 ажилладаг мэт ойлгогдож байна/

6. Хүчин төгөлдөр мөрдөж байгаа Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хуулиар ерөнхий боловсролын лаборатори сургууль, олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байх асуудал хуульчлагдаагүй. Иймээс ерөнхий боловсролын лаборатори сургууль, олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэршил, албан бичгийн хэвлэмэл хуудас болон хичээлийн байрны гадна байршуулах хаягийн бичвэрт боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны “харьяа” гэсэн бичвэрийг хэрэглэхгүй.

Хуульд нийцсэн бичвэр	Хориглох бичвэр
Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын лаборатори сургууль	Баян-Өлгий аймгийн Өлгий сумын лаборатори 3-р сургууль
Дорнод аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Хан-Уул” цогцолбор сургууль	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Дорнод аймгийн лаборатори “Хан-Уул” цогцолбор сургууль
Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 28 дугаар сургууль	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Баянгол дүүргийн үндэсний лаборатори XXVIII сургууль

Харин хүчин төгөлдөр мөрдөж буй “Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт ерөнхий боловсролын тусгай сургууль боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байна”, Дээд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсэгт “Их, дээд сургууль харьяалалдаа ... ахлах сургуультай байж болно” гэж тус тус хуульчилсан байх тул ерөнхий боловсролын тусгай сургууль, их, дээд сургуулийн харьяаллын ахлах сургууль нь сургуулийн нэршлийн өмнө “харьяа” гэсэн бичвэрийг хэрэглэж болно.

7. Их, дээд сургуулийн харьяанд сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа ерөнхий боловсролын ахлах сургууль хууль тогтоомжид тусгайлан заагаагүй “лицей” гэсэн нэр томъёог сургалтын байгууллагын нэр, хаягийн бичвэрт хэрэглэхгүй.

Хуульд нийцсэн бичвэр	Хориглох бичвэр
МУИС-ийн харьяа ерөнхий боловсролын “Байгаль эх” ахлах сургууль	МУИС-ийн “Байгаль эх” лицей ахлах сургууль
АШУҮИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	АШУҮИС-ийн харьяа гүнзгийрүүлсэн сургалттай ЕБС
МУБИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	МУБИС-ийн лицей сургууль
СУИС-ийн харьяа ерөнхий боловсролын Бадмаараг ахлах сургууль	СУИС-ийн Бадмаараг ахлах сургууль
Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяа ерөнхий	Тэмүүжин өрлөг бүрэн дунд сургууль

8. Хаягийн бичвэрт “Нэгдсэн хаягжуулалт. Хаягийн бичвэрт тавих шаардлага MNS 6275:2016” стандартад заасан дор дурдсан ерөнхий шаардлагыг баримтална:

1. Хаягийн бичвэр нь 6 мөрөөс хэтрэхгүй байна;
2. Аль болох товч тодорхой байна;
3. Нэг мөрөнд 40 тэмдэгтээс хэтрэхгүй байна;
4. Хаягийн бичвэрт СУМ, ДҮҮРЭГ, ХОТ зэрэг тодотголыг заавал ашиглах шаардлагагүй;
5. Бичвэрийг мөрийн эхнээс буюу зүүн гар талын эгнээ рүү шахаж бичнэ;
6. Аль болох цэг (.), дундуур зураас (-), хашилтууд (“ ”), таслал (,) дугаарын тэмдэг (№) зэрэг тэмдэгтүүдийг ашиглахгүй байвал зохино;
7. Бүх үсгүүдийг том, дармалаар бичнэ.

Хичээлийн байрны гадна байршуулсан хаягийн бичвэр, албан бичгийн хэвлэмэл хуудас дэх тухайн сургалтын байгууллагын бичвэр нь улсын бүртгэлийн бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэн хуулийн этгээдийн нэртэй тус тус нэгэн адил байна.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ГАЗАР